*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦЫН ТӨСВИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Х.БАТЧИМЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Эрүүл мэндийн сайдын багцын нэгдсэн төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалт хийж, хяналт тавьж, тайлагнах”** | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулах, Сангийн яаманд хүргүүлэх. | 2025 оны хүрээний мэдэгдэл, хязгаарын саналын тоо, хүргүүлсэн төсвийн дүн /хувиар/ | | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж Сангийн яаманд 1 удаа, төсвийн хязгаарыг боловсруулж 1 удаа, төсвийг нэгтгэн хүргүүлсэн байна. 100 хувь | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 1а/1083 дугаар албан бичгээр 19 арга хэмжээнд 1,141,4 тэрбум төгрөг, төсвийн хязгаарын саналыг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1а/2514 дүгээр албан бичгээр 29 арга хэмжээнд 1,291.8 тэрбум төгрөгийн саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. | 2024.03.01-2024.06.10 | 100% |
| 2. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026- | 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн | | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын | 2025 оны төсвийн төсөл, 2026, 2027 оны төсвийн төсөөллийн саналыг эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг сайжруулах, Эрүүл | 2024.07.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2027 оны төсвийн төсөөллийг боловсруулах, Сангийн яаманд санал хүргүүлэх, батлуулах. | төсөөлөлд санал ирүүлсэн байгууллагын тоо, Сангийн яаманд нэгтгэн хүргүүлсэн төсвийн дүн | | сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд ирүүлсэн ЭМБ-уудын саналыг хянаж, нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 1 удаа санал хүргүүлж батлуулсан байна. 100 хувь | мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн багц хуулиуд, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төсвийн удирдамж хүргүүлэх тухай” 01/5374 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу боловсруулж, 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хянуулж, Монгол Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны төсвийн төслийг олон нийтэд ил тодоор мэдээлж цахим хэлбэрээр санал асуулга авч Сангийн яаманд 2024.08.19 2/3401 дүгээр албан бичгээр хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн хүргүүлсэн ба 2024.09.26-ны өдөр Засгийн газрын ордонд нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, Сангийн яам болон олон нийтийн төлөөллийг байлцуулан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | | |
| 3. | Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” журмын төслийн боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах | Журмын төслийн гүйцэтгэлийн хувь | | Журам батлагдсан байна. 100 хувь | Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” журмын төслийг 12 бүлэгтэйгээр боловсруулсан бөгөөд төсвийн төслийг боловсруулах, төлөвлөх, батлуулах, төсөвт өөрчлөлт оруулах, нэмэлт эх үүсвэргийг зарцуулах, төрийн сангийн үйл ажиллагаа болон зардлыг хянах, санхүүгийн тайлан нэгтгэх, хариуцлага ба урамшуулал гэсэн бүлгийн хүрээнд боловсруулж, хэлтсийн хүрээнд танилцуулагдаж удирдлагаас | 2024.01.01-2024.12.31 | 33% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | журмын төслийг дахин сайжруулан боловсруулах чиглэл өгсний дагуу дахин сайжруулалт хийдэж байна. | | |
| 4. | Эрүүл мэндийн байгууллагуудын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд үнэлгээ хийж, хагас жил тутамд зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, төсвийн сахилга батыг сайжруулах | Байгууллагын тоо, Зөвлөмжийн тоо- 2 удаа /хувиар/ | | Сонгосон эрүүл мэндийн байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, болон холбогдох санхүүгийн баримтад дүн шинжилгээ хийж, нэгжийн удирдлагад танилцуулан зөвлөмж чиглэлийн 1 удаа хүргүүлсэн байна. 100 хувь | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд сар бүр эх үүсвэр дутагдаж буй эсэх, өр төлбөр үүссэн эсэх, авлага барагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж нэгжийн удирдлагад тухай бүр танилцуулан ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оны 1а/267, 1а/1721, 1а/2514, 2/3707, 2/3708, 2/3709, 2/3710 дугаарын албан бичгээр 7 удаа, аман байдлаар хөтөлбөр зориулалтын дагуу төсвийг захиран зарцуулж, төсвийн сахилга баттай ажиллах, мөн 2025 оны төсвийн төслийн саналыг үндэслэл тооцоололтой төлөвлөж ирүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 85% |
| 5. | Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн төлөвлөлт, зохицуулалтын нэгтгэл хийж, төсөвтэй холбоотой нэгдсэн тоо мэдээллийг боловсруулах | Нэгтгэсэн мэдээний тоо- 12 удаа /хувиар/ | | Төсөв санхүүтэй холбоотой мэдээлэл боловсруулж, нэгтгэн 12 удаа нэгжийн удирдлагад танилцуулсан байна. 100 хувь | Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн төлөвлөлт, зохицуулалтын нэгтгэл хийж, төсөвтэй холбоотой нэгдсэн тоо мэдээллийг боловсруулах ажлын хүрээнд орон тооны мэдээлэл нэгтгэх дүн шижилгээ хийх, авлага өглөгийн мэдээ тайланг санхүүгийн нэгдсэн тайлан болон төсвийн хэлбэлзэлээс авч дүн шинжилгээ хийж гүйцэтгээд байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/400 дугаар тушаалын хүрээнд ажлын хэсэгт ажиллаж холбогдох тоо мэдээлэлд тооцоолол хийгдэж, танилцуулан төсөлд саналыг тусгуулснаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх журам, хяналт тавих журмыг 05 дугаар тогтоолоор, Төрөөс төлбөрийг нь | 2024.01.01-2024.12.31 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцах эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам, эмийн жагсаалт хэлбэр тун болон Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх журмыг 06 дугаар тогтоолоор баталсан байна. Мөн 2024 оны засгийн газрын 128 дугаар тогтоолын дагуу цалин нэмэгдүүлэх тооцоолол, Засгийн газрын 12 дугаар тогтоолын хүрээнд ЗӨСТ-ийн эмч ажилчдад нөхцлийн нэмэгдэл олгох тооцоолол, Засгийн газрын 82, 83 дугаар тогтоолын хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгох тооцооллыг хийж, нэгжийн удирдлагыг тухай бүр мэдээллээр ханган ажилласан. | | |
| 6. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36.1.2, 36.4 дэх заалт. ”Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах” | Засгийн газрын тогтоолын төсөлд хамаарах чиглэлээр хүргүүлсэн саналын тоо /хувиар/ | | Засгийн газрын тогтоолын төсөлд хамаарах чиг үүргийн саналыг холбогдох газарт 1 удаа хүргүүлсэн байна. 100 хувь | ”Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах” журмын төслийн санхүүжилтийн 4 дүгээр бүлэг “Санхүүжилт” хэсгийг боловсруулалт хийж, удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулсан. /Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан./ | 2024.01.01-2024.06.30 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журмын төсөлд санал хүргүүлэх | | | | | | |
| 7. | Эрүүл мэндийн сайдын багцын дүнгээр тайлагнадаг төсөв, санхүүгийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаанд нь тайлагнах, мэдээллэх | Эрүүл мэндийн сайдын багцын дүнгээр тайлагнадаг төсөв, санхүүгийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаанд нь тайлагнах, мэдээллэх | | Шилэн дансны цахим хуудаст хуулийн хугацаанд 12 удаа мэдээлсэн байна. 100 хувь | Эрүүл мэндийн салбарын нэгдсэн төсвийн үйл ажиллагаатай холбоотойгоор:<br>1. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сар бүр/ – 12 удаа,<br>2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө /жил бүр/ – 1 удаа,<br>3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт /жил бүр/ - 1 удаа,<br>4. Байгууллагын батлагдсан төсөв /жил бүр/ – 1 удаа,<br>5. Дараа жилийн төсвийн төсөл, Хугацаа болоогүй /жил бүр/ - 1 удаа,<br>6. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /жил/ – 1 удаа,<br>7. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /Тухай бүр/ - 12 удаа,<br>8. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /Тухай бүр/ – 12 удаа,<br>буюу 41 удаа Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. | 2024.01.01-2024.21.31 | 100% |
| **Зорилт 2.“ Эрүүл мэндийн сайдын багцын эдийн засаг, санхүү, төсвийн нэгдсэн тооцоолол, судалгаа, дүгнэлт хийж, үр дүнг тайлагнах”** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэх тооцооллыг хийх, санал боловсруулан хүргүүлэх, шаардагдах төсвийг нэмж батлуулах | Хүргүүлсэн албан тоот болон дотоод бичгийн тоо, тооцоолсон төсөв, байгууллагын тоо /хувиар/ | | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишиг батлах тухай ЗГ-ын тогтоолын төсөлд саналыг 1 удаа хүргүүлж тогтоол батлагдаж 3 сар хэрэгжсэн байна. 100 хувь | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишиг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 1 удаа санал боловсруулан удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулж, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан байна. Тогтоол гарсантай холбоотойгоор улсын төсвөөс санхүүждэг 49 байгууллагын 5195 мянган албан хаагчийн цалингийн зардалд 4,4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг байгууллагын 28604 мянган албан хаагчийн цалингийн зардалд 152,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, Сангийн яаманд 2024 оны 1а/1289 дүгээр албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн ТАЦНС программаар 446 байгууллагын 32,8 мянган эмч, эмнэлгийн ажилтанд 1,1 их наяд төгрөгийн цалин хөлс олгож хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2. | Эрүүл мэндийн салбарын аймаг, сум, алслагдсан 3 дүүрэгт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдад олгох орон нутгийн нэмэгдлийг ангилал зэрэглэл харгалзахгүй олгох тооцооллыг хийж санал боловсруулан хүргүүлж, шаардагдах төсвийг нэмж батлуулах | Хүргүүлсэн албан тоот болон дотоод бичгийн тоо, тооцоолсон төсөв, байгууллагын тоо /хувиар/ | | Эрүүл мэндийн салбарын аймаг, сум, алслагдсан 3 дүүрэгт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдад олгох орон нутгийн нэмэгдлийг ангилал зэрэглэл харгалзахгүй олгох тухай ЗГ-ын тогтоолын төсөлд саналыг 1 удаа хүргүүлж | Эрүүл мэндийн салбарын аймаг, сум, алслагдсан 3 дүүрэгт ажиллаж буй эмнэлгийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг ангилал, зэрэглэл харгалзахгүй олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 1 удаа санал боловсруулан удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулж, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан. Тогтоол гарсантай холбоотойгоор 18343 албан хаагчийн цалингийн зардалд 71,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж, 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, Сангийн яаманд 2024 оны 1а/1289 дүгээр албан | 2024.01.01-2024.12.31 | 100% |

64

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтоол батлагдаж, 443 эрүүл мэндийн байгууллагад 3 сар хэрэгжсэн байна. 100 хувь | бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн ТАЦНС программаар 332 сум тосгоны 7959 эмч, эмнэлгийн ажилтан, 21 ЭМГ, ЭМБ болон алслагдсан 3 дүүргийн 11078 эмч, эмнэлгийн ажилтанд бүрэн олгуулан ажиллаж байна. | | |
| 3. | Эрүүл мэндийн сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг хийж батлуулах, мөрдүүлэх | Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаалын тоо, байгууллагын тоо /хувиар/ | | Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн сар, улирлын хуваарийг Эрүүл мэндийн сайдаар 1 удаа батлуулж, 443 эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж мөрдүүлэн ажилласан байна. 100 хувь | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн 2024 оны А/78 дугаар тушаалаар төсвийн хуваарийг батлуулж, 44Є эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Мөн 2024 онд Засгийн газрын 12, 82, 83, 84, 128 дугаар тогтоолууд батлагдан гарсантай холбоотойгоор батлагдсан төсөв, сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/201, А/429 дүгээр тушаалаар батлуулж, сар улирлын хуваарийг мөрдүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 95% |
| 4. | Эрүүл мэндийн сайдын багц, ЭМДСангийн батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлэх | Хуваарьт өөрчлөлт оруулах Байгууллагын тоо, өөрчлөлтийн тоо-12 удаа /хувиар/ | | Хуваарьт 12 удаа өөрчлөлт орсон байна. 100 хувь | Эрүүл мэндийн сайдын багцын гүйцэтгэлийн 62 байгууллага, хосолсон 4, анхан шатны 332, улсын төсвийн 49 байгууллагын төсвийн сар улирлын хуваарийн өөрчлөлт, зохицуулалтын нэгтгэлийг хийж, Сангийн яаманд 2024.01.03 1а/11, 2024.01.24 1а/332, 2024.01.30 1а/411, 2024.02.29 1а/872, 2024.03.15 1а/1090, 2024.04.01 1а/1289, 2024.04.19 1а/1610, 2024.04.30 1а/1809, 2024.05.27 1а/2245, 2024:05.30 1а/2315, 2024.07.24 1а/3033, 2024.08.02 1а/3169, 2024.08.23 1а/3450, 2024.09.04 1а/3618, 2024.10.14 1а/4183, 2024.11.05 1а/4524, 2024.11.20 1а/4854, 2024.11.25 1а/4948, дугаар албан бичгээр батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг тус тус 17 удаа хүргүүлэн шийдвэрлүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Салбарын 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэх, шинэчлэн батлагдахад холбогдох мэдээ, мэдээллийг цаг тухай бүр гаргаж өгөх | Хүргүүлсэн албан тоот болон дотоод бичгийн тоо, байгууллагын тоо /хувиар/ | | Мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт гаргаж, холбогдох газарт санал хүргүүлсэн байна. 100 хувь | Салбарын 3 талт хэлэлцээрийн 2023 оны хэрэгжилтийг дүгнэх, шинэчлэн батлагдахтай холбоотойгоор Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайланг боловсруулан удирдлагад танилцуулж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэн тайланд тусгуулж ажилласан. Боловсруулсан тайлан болон саналын тоо 2. | 2024.01.01-2024.06.30 | 100% |
| 6. | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах мэдээ, мэдээлэл, тооцоо судалгааг гаргах | Хүргүүлсэн албан тоот болон дотоод бичгийн тоо, байгууллагын тоо /хувиар/ | | Мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт гаргаж, төсөвт зохицуулалт хийгдсэн байна. 100 хувь | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зсхион байгуулахад шаардагдах мэдээ, мэдээллийг Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар, Бодлого төлөвлөлтийн газарт тухай бүр хүргүүлэн ажилласан. Мөн зөвлөгөөнтэй холбоотой гарах зардлын тооцооллыг хийж, 2024 оны төсвийн хуваарийн өөрчлөлтөөр зохицуулалт хийх саналыг 2024.04.01 1а/1289, 2024.10.14 1а/4183-ны албан бичгээр төсөвт зохицуулалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлэн Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2 удаа амжилттай зохион байгуулсан байна. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| **Зорилт 3. “ Гүйцэтгэлээр санхүүжих эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн зарцуулалтын эрх олгох, зохицуулалт, хяналт тавьж арга зүйгээр хангах”** | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн зарлагын төлөвлөлтийг орлоготой уялдуулан төлөвлөх, төсвийн нэгдсэн программд оруулах | Сангийн яамны FISCAL программ ашиглаж байгаа байгууллагын тоо /хувиар/ | FISCAL программ 21 аймаг, нийслэлд нэвтэрсэн . | Гүйцэтгэлээр санхүүжиж буй 66 эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зохицуулалтын саналыг судлан тухай бүр нь Fiscal программд нэгтгэн өөрчлөлт | Эрүүл мэндийн сайдын багцын лавлагаа 66 байгууллага, анхан шатны 332 байгууллагын төсвийн сар, улирлын хуваарийн өөрчлөлт, зохицуулалтыг FISCAL программаар хүлээн авч хянан, нэгтгэлийг Сангийн 2024.01.03 1а/11, 2024.01.24 1а/332, 2024.01.30 1а/411, 2024.02.29 1а/872, 2024.03.15 1а/1090, 2024.04.01 1а/1289, 2024.04.19 1а/1610, 2024.04.30 1а/1809, 2024.05.27 1а/2245, 2024:05.30 1а/2315, 2024.07.24 1а/3033, 2024.08.02 1а/3169, 2024.08.23 1а/3450, 2024.09.04 1а/3618, 2024.10.14 1а/4183, 2024.11.05 1а/4524, 2024.11.20 1а/4854, | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулсан байна. 100 хувь | 2024.11.25 1а/4948 дугаар албан бичгээр нийт 18 удаа хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Мөн Сангийн яамнаас хянагдаж, шинэчлэгдсэн баазыг хүлээн авч аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргүүлж ажилласан. | | |
| **Зорилт 4. " Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэх"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1.1. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсрууж батлуулах | Гүйцэтгэлийн хувь | - | 100 хувь | Арга хэмжээ 4.1.1. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан нэгжийн даргаар хянан баталгаажуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2024.01.01-2024.02.29 | 100% |
| 2. | Арга хэмжээ 4.1.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах | Хэрэгжилтийн хувь | | 100 хувь | ХОМ-ийг Авилгын эсрэг хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд 1 удаа үнэн зөв мэдээллэсэн. | 2024.01.01-2024.02.29 | 100% |
| 3. | Удирдлага болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | Мэдээллийн тоо | 2023 оны гүйцэтгэлийн тайлан | Удирдлага болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангасан байна. | "Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн удирдамж"-ийн дагуу нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, үүссэн шалтгааныг тодруулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн бөгөөд, ажлын тайланг ажлын хэсгийн нарийн бичигт хүлээлгэн өгсөн.<br>2023 оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл түүний анхан шатны баримт болон холбогдох мэдээллийг Үндэсний аудитын газар болон АТГ-д, МЭМАУЭХ, Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газар, | 2024.01.01-2024.12.31 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол улсын их хурлын нийгмийн бодлогын байнгын хороонд нэмэлт тайлбар, тодруулгыг гаргаж өгсөн. Мөн 2024 оны батлагдсан төсөвт нэмэлт тодотгол хийлгэх саналын тооцооллыг хийж, 2024.07.22 1а/2997, 2024.08.09 1а/3302 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлсэн. | | |
| 4. | Архив, албан хэрэг хөтлөлт, тайлан, мэдээг цаг тухайд нь тайлагнах, хяналт тавих | Үүсгэсэн архивын нэгжийн тоо | Хөтлөх нэрийн жагсаалт | Албан хэргийг стандартын дагуу хөтөлж, архивын нэгж үүсгэсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 2024 оны төсвийн төсөл, 2025, 206 оны төсвийн төсөөллийн баримт бичгийг архивын нэгж үүсгэж, архивын ажилтанд хүлээлгэн өгсөн. | 2024.01.01-2024.04.30 | 100% |
| 5. | Удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | Тушаалын огноо, дугаар | 90 хувь | Үүрэг даалгаварыг чанартай гүйцэтгэсэн байна. | Ур чадварын нэмэгдлийг журмын төсөлд тусгуулахаар нэмэлт шаардлагатай санхүүжилтийн тооцооллыг хийж, саналыг дотоод меморандумаар БТГ-т өгч журмын төсөлд тусгуулсан.<br>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг холбогдох мэргэжилтнээс хүлээн авч нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хүргүүлсэн тайлангийн тоо 11 удаа. | 2024.01.01-2024.12.31 | 80% |
| 6. | Албан бичиг, өргөдөл хүсэлтийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах | Албан бичгийн тоо | 100 хувь | Хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна. | Байгуулага болон иргэнээс ирүүлсэн өргөдөлтэй холбоотойгоор холбогдох анхан шатны материал болон нөхцөл байдал эрх зүйн орчныг судлан үзэж, өргөдөл гомдлын болон албан бичгийн хариуг тухай бүр хуулийн хугацаанд хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 90% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Нүүдлийн клиник" худалдан авах, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн | Зөвлөмж, мэдэгдэл | | Сонгон шалгаруулалтыг зохин байгуулсан байна. | 1. ТНБД-ын 2024 оны А/51 дүгээр тушаалаар "Үнэлгээний хороо байгуулах тухай" ажлын хэсэгт ажиллаж 3 удаагийн хуралд оролцож, нүүдлийн клиник нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон | 2024.01.01-2024.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2024-2026 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх Салбар хүлээн авагч байгууллагыг сонгон шалгаруулах | | | | шалгаруулалтыг зохион байгуулахад гишүүнээр оролцсон бөгөөд зөвлөмж мэдэгдлийг ТНБД-д хүлээлгэн өгсөн ба оролцогч байгууллагаас гомдол, санал ирүүлээгүй болно.<br>2. ТНБД-ын 2023 оны А/108 дугаар тушаалаар "Үнэлгээний хороо байгуулах тухай" ажлын хэсэгт ажиллаж Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн 2024-2026 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх Салбар хүлээн авагч байгууллага сонгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад гишүүнээр оролцож 5 удаагийн хуралд оролцож оролцогчийг сонгон шалгаруулсан бөгөөд зөвлөмж мэдэгдлийг ТНБД-д хүлээлгэн өгсөн ба оролцогч байгууллагаас гомдол, санал ирүүлээгүй байна. | | |
| 2. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 48 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг хэрэгжүүлэх | Саналын тоо | | Холбогдох саналыг хүргүүлсэн байна. | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/07 дугаар тушаалын дагуу захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийх ажлын хэсэгт ажиллаж газар, хэлтсийн саналыг нэгтгэн, удирдлагад танилцуулж, ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. | 2024.01.01-2024.03.22 | 100% |
| 3. | Төрийн цахим шижилтийг хийж, хэрэгжүүлэх | Цахимд шилжсэн байгууллагын тоо | | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн мөнгөн тэтгэмж, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг ТАЦНС программаар | 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн дагуу "Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн мөнгөн тэтгэмж"-ийг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр олгуулж орон нутгийн 396 байгууллага цахим системд шилжсэн ба Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн дагуу "Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмж"-ийг 46 нийслэл дэх эрүүл мэндийн байгууллага, 21 аймгийн эрүүл мэндийн газрыг тус тус цахимжуулахтай | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олгуулсан байна. | холбоотой 3 удаагийн сургалтыг Сангийн яамтай хамтран зохион байгуулж зөвлөмж, чиглэл өгч ажилласан. | | |
| 4. | Эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт хийх | Төрийн нарийн бичгийн даргын тушаал, удирдамж | | Дэмжлэгт хяналт хийсэн байгууллагын тоо | 1. Төрийн нарийн бичгийн даргын 2024.01.08-ны өдөр баталсан удирдамж, 2024.06.25-ны өдөр баталсан А/82 дугаар тушаалын дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвсанхүү, төсөв, удирдлага зохион байгуулалтад дэмжлэгт хяналтыг хийж, тайланг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нарт тухай бүр хүргүүлэн ажилласан.<br>2. 2025 оны ЭМДСангийн оношийн хамааралтай бүлгийн тарифт өөрчлөлт оруулахаар асуудалтай, санхүүжилт хүндэрч буй ЭМБ-уудын төлөөлөл /АӨСҮТ, ЭХЭМҮТ/-ийг хүлээн авч төслийн багтай хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Мэргэшсэн нягтлан бодогчийн институтаас зохион байгуулсан багц цагийн сургалтад танхим эсвэл онлайнаар хамрагдсан байна. | Судалсан хичээлийн нэр | | Сургалтад хамрагдсан байна. | Мэргэшсэн нягтлан бодогчийн институтаас зохион байгуулсан тасралтгүй боловсрол олгох багц цагийн сургалтад онлайнаар хамрагдаж 40 кр цагийн 21 хичээл судалсан. | 2024.01.01-2024.06.30 | 100% |
| 2. | Удирдлагын академид Дунд хугацааны давтан мэргэшүүлэх багц | Судалсан хичээлийн нэр | | Сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдаж, нийт 9 кр цуглуулахаас 1 дүгээр семистерт 6 кр цуглуулсан ба, 2 дугаар семистерт 5 кр | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цагийн сургалтад хамрагдсан байна. | | | | цуглуулахаар сургалтад хамрагдаж байна. Сургалт 2024.12.13-ны өдөр дуусна. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн нэгдсэн төлөвлөлт, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн | ................................... Х.Батчимэг | 2024.12.05 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |